

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүн амын ядуу, эмзэг байдалд өртсөн зорилтот өрх, иргэний наад захын хэрэгцээг хангах, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн үйл ажиллагааг хөдөлмөр эрхлүүлэхтэй уялдуулах замаар ядуурлаас гаргах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Нийгмийн халамжийн хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн халамжид хамрагдах эрхтэй.

3.2.Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтад заасны дагуу Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас регистрийн дугаар авсан Монгол Улсад оршин суух зөвшөөрөл бүхий иргэн байна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

¹Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

4.1.1.“нийгмийн халамж” гэж зорилтот өрх, иргэнд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгох, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн арга хэмжээг;

4.1.2.“зорилтот өрх, иргэн” гэж нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай дараах өрх, иргэнийг:

4.1.2.а.ахмад настан;

4.1.2.б. хөгжлийн бэрхшээлтэй;

4.1.2.в.өрх толгойлсон эх, эцэг;

4.1.2.г.Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхэд;

4.1.2.д.байнгын асаргаа шаардлагатай;

4.1.2.е.гэр оронгүй тэнэмэл амьдралтай;

4.1.2.ё.архинд донтох өвчтэй;

4.1.2.ж.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэн;

4.1.2.з.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-д заасан аюулт үзэгдэлд нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх, иргэн.

4.1.3.“нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэн” гэж амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугам болон энэ зүйлийн 4.1.5-д заасан босго онооноос доогуур байгаа өрх, иргэнийг;

4.1.4.“ядуурлын шугам” гэж Үндэсний статистикийн хорооноос өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд үндэслэн нэг хүний сарын амьжиргааны доод түвшинг тодорхойлсон мөнгөн дүнг;

4.1.5.“босго оноо” гэж нийгмийн халамжийн тухайн арга хэмжээнд хамрагдах зорилтот өрх, иргэнийг тодорхойлох зорилгоор амьжиргааны түвшинг нь үнэлж, эрэмбэлсэн онооны хязгаарыг;

4.1.6.“ахмад настан” гэж Ахмад настны тухай хуулийн² 3 дугаар зүйлийн 3.1-т заасан хүнийг;

4.1.7.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн³ 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан хүнийг;

4.1.8.“байнгын асаргаа шаардлагатай иргэн” гэж өвчин, эмгэгийн улмаас өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй болсон эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэйг нь эрх бүхий байгууллагаас тогтоосон хүнийг;

4.1.9.“бүтэн өнчин хүүхэд” гэж эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх, эцэг нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг;

4.1.10.“өрх толгойлсон эх, эцэг” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн

²Ахмад настны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 13 дугаарт нийтлэгдсэн.

³Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2016 оны 9 дүгээрт нийтлэгдсэн.

шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие хүнийг;

4.1.11.“зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээ” гэж төрийн болон төрийн бус байгууллагын санаачилга, хамтын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг, тусламж, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг;

4.1.12.“асрамжийн үйлчилгээ” гэж бие даан амьдрах чадваргүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг байрлуулж амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хамгаалах хувилбарт арга хэмжээг;

4.1.13.“нийгмийн халамжийн үйл ажиллагаа” гэж зорилтот өрх иргэнийг илрүүлэх, бүртгэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулах, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд холбон зуучлах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх үйл явцыг.

5 дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.2.хүмүүнлэг энэрэнгүй байдлыг эрхэмлэх;

5.1.3.хүн амын ядуурал, эмзэг байдлыг бууруулах;

5.1.4.зорилтот өрх, иргэний хэрэгцээнд тулгуурласан, амьдралын чанарт эерэг өөрчлөлт гарахад чиглэх;

5.1.5.зорилтот өрх, иргэнийг чадавхижуулах, хөдөлмөр эрхлүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;

5.1.6.төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, хамт олны оролцоонд тулгуурлах.

6 дугаар зүйл.Нийгмийн халамжийн арга хэмжээний төрөл

6.1.Нийгмийн халамжийн арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

6.1.1.нийгмийн халамжийн тэтгэвэр;

6.1.2.нийгмийн халамжийн тэтгэмж;

6.1.3.нийгмийн халамжийн дэмжлэг;

6.1.4.нийгмийн халамжийн үйлчилгээ.

6.2.Энэ зүйлийн 6.1-д заасан арга хэмжээ болон бусад хууль тогтоомжийн дагуу өрхөд төрөөс олгож байгаа нийт мөнгөн тэтгэмж, тусламжийн нэг гишүүнд сард ногдох дээд хязгаарыг тухайн өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан ялгаатай тогтоох бөгөөд аргачлалыг санхүү төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.3.Энэ хуулийн 4.1.5-д заасан босго оноог Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлалын дагуу амьжиргааны түвшинг нь үнэлж, эрэмбэлсэн өрхөөс нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ

7 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр

7.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид “халамжийн тэтгэвэр” гэх/-ийг дараах нөхцөлийг хангасан иргэнд сар бүр олгоно:

7.1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

7.1.2. хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 18 нас хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй;

7.1.3. 18 нас хүрсэн одой иргэн;

7.1.4. тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд;

7.1.5. хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд.

7.2. Энэ зүйлийн 7.1.1-7.1.4-д заасан иргэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн бол тэтгэврийг давхардуулан олгохгүй.

8 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэмж

8.1. Нийгмийн халамжийн тэтгэмж /цаашид “халамжийн тэтгэмж” гэх/-ийг дараах иргэнд сар бүр олгоно:

8.1.1. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэн;

8.1.2. байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа иргэн;

8.1.3. тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн;

8.1.4. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны, бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн;

8.1.5. 18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг.

8.2. Ахмад настан болон 18-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг аймаг, дүүргийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комисс, 18 нас хүртэлх хүүхдийн байнгын асаргаа шаардлагатай эсэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тус тус 6-аас 36 хүртэлх сараар тогтоох буюу сунгана.

8.3. Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-д заасан байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлох өвчин, эмгэгийн жагсаалт, өөртөө туслах чадварын үнэлгээ, зааврыг эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

9 дүгээр зүйл.Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

9.1.Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээ, хэрэглээний үнийн индексийн өөрчлөлттэй уялдуулан Засгийн газар тогтооно.

9.2.Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ахмад настны тэтгэврийн хэмжээ нь нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээний 50 хувьтай тэнцүү байна.

9.3.Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 18 нас хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн,18 нас хүрсэн одой иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэврийн хэмжээ хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн тухайн үеийн дунджаас багагүй байна.

9.4.Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэврийг нас барсан тэжээгчийн нэг хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээгээр, 2 ба түүнээс дээш хүүхэдтэй бол хүүхэд тутамд халамжийн тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэн тооцно.

9.5.18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмжийг нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэжээгчээ алдсаны тэтгэвэртэй давхардуулан олгохгүй.

10 дугаар зүйл.Тэтгэвэр, тэтгэмж авах хүсэлт гаргах

10.1.Тэтгэвэр, тэтгэмж авахыг хүссэн иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, сум, хорооны нийгмийн ажилтанд биечлэн болон цахимаар өргөдөл гаргана.

10.2.Нийгмийн халамжийн 2 буюу түүнээс дээш арга хэмжээнд хамрагдаж байгаа иргэн энэ хуулийн 10.1-д заасан баримт бичгийг давхардуулан бүрдүүлэхгүй.

10.3.Сум, хорооны нийгмийн ажилтан тэтгэвэр, тэтгэмж авах иргэний баримт бичиг, өргөдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 хүртэлх хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

10.4.Тэтгэвэр, тэтгэмж авах иргэний өргөдөл, хувийн хэрэг болон бусад маягтын загварыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

11 дүгээр зүйл.Тэтгэвэр, тэтгэмж олгох

11.1.Тэтгэвэр, тэтгэмжийг иргэний өргөдөл гаргасан өдрөөс эхлэн тооцож, түүний сонгосон арилжааны банк дахь харилцах дансаар дамжуулан олгоно.

11.2.Тэтгэвэр, тэтгэмж авагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрөө хүсэлт гаргавал улиралд олгох тэтгэвэр, тэтгэмжийг тухайн улирлын эхний сард бөөнөөр нь олгож болно.

11.3.18 хүртэлх насны хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно.

11.4.Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.

12 дугаар зүйл.Тэтгэвэр, тэтгэмж олголтыг зогсоох

12.1.Тэтгэвэр, тэтгэмж олголтыг дараах үндэслэлээр зогсооно:

12.1.1.хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадвар сэргэсэн эхсүл хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ 50 хувиас доош тогтоогдсон бол дараа сараас;

12.1.3.тэжээгч нь нас барсны тэтгэвэр авагч хүүхэд 18 нас хүрсэн өдрөөс;

12.1.4.энэ хуулийн 8.1.5-д заасан хүүхдийн тоо 3-аас бага болсон бол дараа сараас;

12.1.5.тэтгэвэр, тэтгэмж авагч нас барсан бол нас барсны дараа сараас;

12.1.6.энэ хуулийн 8.1.1-д заасан иргэний асарч байгаа хүнд байнгын асаргаа шаардлагагүй болсон бол дараа сараас;

12.1.7.хуурамч баримт бичиг бүрдүүлж тэтгэвэр, тэтгэмж авсан бол нийгмийн халамжийн улсын байцаагчийн актыг үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын шийдвэрт заасан хугацаанаас;

12.1.8.тэтгэвэр, тэтгэмж авагч Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсон өдрөөс;

12.1.9.Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа тэтгэвэр, тэтгэмж авагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсаас бүр мөсөн буцах хүсэлт гаргасан бол Монгол Улсын хилээр гарсан өдрөөс.

ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ

13 дугаар зүйл.Нийгмийн халамжийн дэмжлэг

13.1.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд нийгмийн халамжийн дараах дэмжлэг үзүүлнэ:

13.1.1.хүнс тэжээлийн дэмжлэг;

13.1.2.боловсрол эзэмшихэд үзүүлэх дэмжлэг;

13.1.3.эрүүл мэндийн дэмжлэг.

13.2.Нийгмийн халамжийн дэмжлэгийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

14 дүгээр зүйл.Хүнс тэжээлийн дэмжлэг

14.1.Хүнс тэжээлийн дэмжлэгийг амьжиргааны түвшин нь босго онооноос доогуур үнэлгээтэй өрхөд сар бүр олгоно.

14.2.Хүнс тэжээлийн дэмжлэгийг хүнсний бүтээгдэхүүн худалдан авах цахим картаар олгоно.

14.3.Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдах хугацаа нь 24 сар байх бөгөөд тухайн өрхийн амьжиргааны түвшний үнэлгээ болон энэ зүйлийн 14.6-д заасан нөхцөлийн биелэлт, идэвхи оролцоонд үндэслэн 24 хүртэлх сараар сунгана.

14.4.Энэ зүйлийн 14.3-т заасан хугацааны дараа тухайн өрхийн амьжиргааны түвшний үнэлгээ нь хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдахаар байвал дэмжлэгийн хэмжээг 50 хувиар бууруулан нэг удаа 12 сараар сунгаж, дахин сунгахгүй.

14.5.Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдаж байгаа өрхөд хөдөлмөрийн чадвартай хөдөлмөрийн насны иргэн байхгүй бол энэ зүйлийн 14.4 дэх заалт хамаарахгүй.

14.6.Хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдаж байгаа өрхийн гишүүд нь дараах нөхцөлийг биелүүлэх үүрэгтэй:

14.6.1.хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах;

14.6.2.хүүхдээ товллын дагуу заавал хийх дархлаажуулалтад бүрэн хамруулах;

14.6.3.сургуулийн насны хүүхдээ албан эсхүл албан бус боловсролд бүрэн хамруулж, хүүхдэд суурь боловсрол заавал эзэмшүүлэх.

14.7.Энэ зүйлийн 14.6.1 дэх заалтад дараах иргэн хамаарахгүй:

14.7.1.жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх эсхүл эцэг;

14.7.2.хүүхэд нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй бол 6 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эх эсхүл эцэг;

14.7.3.байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа иргэн;

14.7.4.их, дээд сургууль, коллеж, политехник коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа;

14.7.5.хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан иргэн;

14.7.6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэн;

14.7.8.Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны хугацаат цэргийн албанд татагдсан иргэн.

14.8.Сум, хорооны нийгмийн ажилтан нь иргэний үнэмлэхгүй, шилжилт хөдөлгөөний бүртгэлгүй өрхийг илрүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийж гурав хүртэлх сарын хугацаанд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлнэ. Энэ хугацаанд улсын бүртгэлийн ажилтантай хамтран бичиг баримтын зөрчлийг арилган шаардлагатай бол нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулна.

15 дугаар зүйл.Боловсрол эзэмшихэд үзүүлэх дэмжлэг

15.1.Амьжиргааны түвшин нь босго онооноос доогуур үнэлгээтэй өрхийн 18 хүртэлх насны ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхэд тус бүрд боловсрол эзэмшихэд нь зориулж дараах дэмжлэг үзүүлнэ:

15.1.1.үдийн хоолны үнийн;

15.1.2.сурагчийн дүрэмт хувцасны үнийн;

15.1.3.сурах бичиг, хичээлийн хэрэгслийн үнийн;

15.1.4.12-18 хүртэлх насны хүүхдэд нийтийн тээврийн үнийн.

15.2.Амьжиргааны түвшин нь босго онооноос доогуур үнэлгээтэй өрхийн төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн хоолны зардлыг төрөөс хариуцна.

15.3.Үдийн хоолны болон сурах бичиг, хичээлийн хэрэгслийн болон нийтийн тээврийн үнийн дэмжлэгийг жилд нэг удаа, сурагчийн дүрэмт хувцасны дэмжлэгийг 2 жилд нэг удаа Засгийн газрын тогтоосон жишиг үнээр тооцон олгоно.

16 дугаар зүйл.Эрүүл мэндийн дэмжлэг

16.1.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд эрүүл мэндийн дараах дэмжлэг үзүүлнэ:

16.1.1.эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцах;

16.1.2.нөхөн үржихүйн насны эмэгтэйд жирэмслэлтээс хамгаалах эм, хэрэгслийг өөрийн хүсэлтэд үндэслэн хөнгөлөлттэй үнээр олгох;

16.1.3.“жирэмсэн эмэгтэйд олон найрлагатай бичил тэжээлийн дэмжлэгийг хөнгөлөлттэй үнээр олгох”;

16.1.4.архинд донтох өвчтэй иргэний донтолтыг бууруулах эмийг хөнгөлөлттэй үнээр олгох;

16.1.5.архинд донтох өвчтэй иргэн өөрийн санаачилгаар сайн дурын үндсэн дээр донтох өвчнөө эмчлүүлэх хүсэлтэй бол хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлыг хариуцах.

16.2.Энэ зүйлийн 16.1.2-16.1.4-т заасан бичил тэжээл, эм, хэрэгслийн төрөл, хөнгөлөлтийн хэмжээ, мөн зүйлийн 16.1.5-т заасан хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардлын хэмжээг эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл батална.

16.3.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг санхүүжүүлэх зардлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

17 дугаар зүйл.Нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл

17.1.Нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

17.1.1.зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээ;

17.1.2.олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөгжлийн үйлчилгээ;

17.1.3.асрамжийн үйлчилгээ.

17.2.Нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

18 дугаар зүйл.Зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээ

18.1.Зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5.2-т заасан Нийгмийн хөгжлийн

зорилтот хөтөлбөртэй уялдуулан нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

18.2.Зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

18.1.1.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний амьжиргааг дэмжих урт хугацааны (цаашид амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээ гэх);

18.1.2.цочролын сөрөг нөлөөг бууруулах;

18.1.3.архинд донтох өвчтэй иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх;

18.1.4.гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх.

18.3.Зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх замаар хамтран хэрэгжүүлнэ.

18.4.Энэ зүйлийн 18.3-т заасан төрийн бус байгууллага нь орон тооны нийгмийн ажилтантай, тухайн чиглэлээр мэргэшсэн, үйлчилгээний чанарт тавигдах шалгуурыг бүрэн хангасан байна.

18.5.Зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээг үзүүлэх төрийн бус байгууллагыг тогтмол хугацаанд чадавхижуулах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэний амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээ

19.1.Амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээг 36 хүртэлх сарын хугацаанд тухайн шатны Засаг дарга нь нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага болон тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гэрээт төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлнэ.

19.2.Амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээг дараах үе шатаар хэрэгжүүлнэ:

19.2.1.үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тухайн шатны Засаг дарга, сум, хорооны нийгмийн ажилтан, Амьжиргааг дэмжих зөвлөл хамтран нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу судалж, сонгох;

19.2.2.үйлчилгээнд хамрагдах өрх, иргэний нөхцөл байдалд үнэлгээ хийх;

19.2.3.энэ хуулийн 19.2.2-д заасан үнэлгээнд үндэслэн тухайн өрхийн гишүүнтэй хамтран тухайн өрхийн нөхцөл байдал, хэрэгцээ, нөөц боломж, чадавхид тулгуурлан өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх зорилготой Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгцээт нийгмийн үйлчилгээний багцыг тодорхойлох;

19.2.5.Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу өрх, иргэнийг нийгмийн халамжийн зохих арга хэмжээнд хамруулж, боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлт, хууль зүйн зэрэг нийгмийн бусад үйлчилгээ, дэмжлэгт холбон зуучлах;

19.2.6.өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах;

19.2.7.амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, орлогын тогтвортой эх үүсвэр, хуримтлалтай болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.

19.3.Амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хэмжээний төлөөлөл бүхий төрийн бус байгууллагатай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.23-д заасан ерөнхий гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах үүргийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

19.4.Ерөнхий гэрээг 3 хүртэлх жилийн хугацаагаар байгуулж, гэрээнд амьжиргааг дэмжих урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэх сум, хорооны болон төрийн бус байгууллага, ажилтныг сургах, мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын үр дүнг үнэлэх, оролцогч талын эрх, үүрэг, орон нутгийн түвшинд бүх шатны Засаг дарга, байгууллага, ажилтантай хамтран ажиллах зэрэг асуудлыг тусгана.

20 дугаар зүйл.Цочролын сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ

20.1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-д заасан хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээ алдсан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд учирсан хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн цочролын сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг үзүүлнэ.

20.2.Цочролын сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

20.2.1.хүнс тэжээлийн дэмжлэгт хамруулах;

20.2.2.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, Хүн амын өсөлтийг дэмжих тухай хуулийн 5.1.2-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хэмжээг нэмэгдүүлэн олгох;

20.2.3.аюулт үзэгдлийн улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх;

20.2.4.сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

20.2.5.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах.

20.3.Цочролын сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг тухайн өрхийн хэрэгцээнд үндэслэн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага сонгон үзүүлнэ.

20.4.Энэ хуулийн 20.2.2-т заасан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдүүлэн олгох хэмжээ, 20.2.3-т заасан аюулт

үзэгдлийн улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр худалдан авахад нь үзүүлэх дэмжлэгийн хэмжээг тус тус Засгийн газар тогтооно.

21 дүгээр зүйл.Архинд донтох өвчтэй иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ

21.1.Сум, хорооны нийгмийн ажилтан, Амьжиргааг дэмжих зөвлөл, гэрээт төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан хамтарсан багаар ажиллаж нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн архидан согтуурах донтой иргэнийг илрүүлж, тухайн иргэн эсхүл гэр бүлийн гишүүний хүсэлтэд үндэслэн дараах үйлчилгээ үзүүлнэ:

21.1.1.нөхцөл байдлын үнэлгээ хийх;

21.1.2.тухайн иргэнд үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах;

21.1.3.зан үйл, хандлагыг өөрчлөх ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах;

21.1.4.өөрийн санаачилгаар донтох өвчнөө эмчлүүлэх бол донтолтоос ангижруулах эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээнд зуучлан хамруулах;

21.1.5.бие даан амьдрах чадвар, дадлыг хэвшүүлэх, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх хандлагыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах;

21.1.6.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд холбон зуучлах.

21.2.Архидан согтуурах донтой иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

22 дугаар зүйл.Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ

22.1.Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг аймаг, нийслэлийн Засаг дарга, тухайн шатны нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, мэргэшсэн төрийн бус байгууллага дараах үйлчилгээг үзүүлнэ:

22.1.1.гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнийг илрүүлэх, түр хоноглох байранд байрлуулан хоол, хүнс, ахуйн наад захын хэрэгцээгээр хангах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах;

22.1.2.нөхцөл байдлын үнэлгээ хийх;

22.1.3.тухайн иргэнд үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөөг хамтран боловсруулах;

22.1.4.бичиг баримтжуулах, эрүүл мэнд, боловсрол, соёл зэрэг нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах;

22.1.5.зан үйл, хандлагыг өөрчлөх ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн засалд хамруулах;

22.1.6.өөрийн санаачилгаар архинд донтох өвчнөө эмчлүүлэх бол донтолтоос ангижруулах эмчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээнд зуучлан хамруулах;

22.1.7.бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх хандлагыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах;

- 22.1.8.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд холбон зуучлах;
- 22.1.9.гэр бүлд нь эргэн нэгтгэх.

22.2.Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэнийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээний зардлыг аймаг, нийслэлийн төсвөөс хариуцан санхүүжүүлнэ.

23 дугаар зүйл.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөгжлийн үйлчилгээ

23.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөгжлийн дараах үйлчилгээг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн хөгжлийн төвөөр дамжуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр үзүүлнэ:

23.1.1.соёл, урлаг, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ;

23.1.2.интернет, цахим үйлчилгээ ашиглах, ухаалаг утас хэрэглэх, дохионы хэл заах, бие бялдрын боловсрол олгох, амьдрах ухаанд сургах зэрэг хувь хүнийг хөгжүүлэх, нийгмийн оролцоог дэмжих сургалт;

23.1.3.ижил хүсэл, сонирхолтой иргэдийн бүлгийн хөгжлийг дэмжих.

23.2.Тав ба түүнээс дээш жил хорих ял эдлээд суллагдсан ганц бие, өөрийн гэсэн орон гэргүй иргэнийг бичиг баримтжуулах, орон гэртэй болгох, бие даан амьдрахад нь туслах, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, ажил орлоготой болгох цогц арга хэмжээг аймаг, нийслэлийн төсвөөс хариуцан санхүүжүүлж, хэрэгжүүлнэ.

23.3.18 нас хүрсэн бүтэн өнчин болон асрамжийн газраас гарч байгаа хүүхдийг бие даан амьдрах, хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болох, орон сууцны бага хүүтэй зээлд хамруулахад нь дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар баталж, аймаг, нийслэлийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

23.4.Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-18 хүртэлх насны хүүхэд болон осол, гэмтэлд өртсөн, амь тэнссэн, эмнэлгийн яаралтай тусламж авах хойшлуулшгүй нөхцөл байдал үүссэн иргэнд орон нутгийн агаарын тээврээр хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх журмыг зам тээврийн, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, зардлыг зам тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусгана.

24 дүгээр зүйл.Асрамжийн үйлчилгээ

24.1.Асрамжийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага үзүүлнэ.

24.2.Төрөөс үзүүлэх асрамжийн үйлчилгээнд дараах иргэнийг хамруулна:

24.2.1.тэжээн тэтгэх хүүхэдгүй бие даан амьдрах чадваргүй ганц бие ахмад настан;

24.2.2.тэжээн тэтгэх хүүхэдгүй бие даан амьдрах чадваргүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

24.2.3.тэжээн тэтгэх хүүхэд нь хорих ял эдэлж байгаа, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь тухайн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эсрэг хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон бие даан амьдрах чадваргүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

24.2.4.Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхэд.

24.3.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага асрамжийн үйлчилгээг энэ зүйлийн 24.2-т зааснаас бусад иргэний хүсэлтийн дагуу түр эсхүл урт хугацаагаар, өдрөөр болон явуулын хэлбэрээр төлбөртэй үзүүлж болно.

24.4.Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь энэ зүйлийн 24.2-т заасан иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлэх тохиолдолд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх нэг асруулагчид үзүүлэх хувьсах болон үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

24.5.Үйлчлүүлэгчийн нас, эрүүл мэндийн байдал, онцлог хэрэгцээг харгалзан асрамжийн үйлчилгээг ангилж, төрөлжүүлж болно.

24.6.Энэ зүйлийн 24.2.1-24.2.3-т заасан иргэнийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын, мөн зүйлийн 24.2.4-т заасан хүүхдийг аймаг, дүүргийн хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын саналыг тус тус үндэслэн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, дүүргийн Засаг дарга гаргана.

24.7.Асрамжийн үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

24.8.Энэ зүйлийн 24.2, 24.4-т заасан үйлчилгээнд хүүхэд, иргэнийг хамруулах, шилжүүлэх, гаргах болон асрамжийн байгууллагын санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.9.Энэ зүйлийн 24.2, 24.4-т заасан үйлчилгээнд хамрагдах нэг асруулагчид ногдох хоол хүнс, хувцас, зөөлөн эдлэл, эм, живх, ариун цэврийн болон эмнэлгийн туслах хэрэгсэл, оршуулгын зардал, сургалтын хэрэглэгдэхүүний хувьсах болон үйлчилгээний зардлын хэмжээг санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

24.10.Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа энэ зүйлийн 24.2.1-24.2.3-д заасан иргэний нийгмийн халамж, даатгалын тэтгэврийн 60 хувийг өөрт нь олгож, 40 хувийг асруулагчдын эрүүл мэнд, хөгжил, оролцоог дэмжих үйл ажиллагаанд зарцуулна.

24.11.Энэ зүйлийн 24.10-т заасан хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг санхүү төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

24.12.Энэ зүйлийн 24.2-т заасан асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, олон улсын

байгууллагаас өгсөн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.13.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл, магадлан итгэмжлэлийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.

24.14.Асрамжийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24.15.Асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэнд энэ хуулийн 8.1-д заасан тэтгэмжийг олгохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

25 дугаар зүйл.Нийгмийн халамжийн сан

25.1.Нийгмийн халамжийн сан /цаашид “халамжийн сан” гэх/ нь мөнгөн хөрөнгийн сан байна.

26 дугаар зүйл.Халамжийн сангийн орлогын эх үүсвэр

26.1.Халамжийн сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 26.1.1.улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- 26.1.2.олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж;
- 26.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;
- 26.1.4.банкинд байршсан сангийн хөрөнгийн үлдэгдлийн хүү;
- 26.1.5.бусад эх үүсвэр.

26.2. Энэ зүйлийн 26.1.2, 26.1.3-т заасан хандив, тусламжийг хүлээн авч бүртгэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

27 дугаар зүйл.Халамжийн сангийн зарцуулалт

27.1.Халамжийн сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

- 27.1.1.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж;
- 27.1.2.нийгмийн халамжийн дэмжлэг;
- 27.1.3.нийгмийн халамжийн үйлчилгээ;
- 27.1.4.Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан тусламж, дэмжлэг, хөнгөлөлт, үйлчилгээ;
- 27.1.5.Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны зардал, зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал;
- 27.1.6.нийгмийн халамжийн салбарын хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтын зардал;
- 27.1.7.нийгмийн халамжийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах, хөгжүүлэх зардал;

27.1.8.өрхийн амьжиргааны түвшин тогтоох, дахин үнэлэх, өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, шинэчлэх зардал;

27.1.9.нийгмийн халамжийн бодлого, үр нөлөө, үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ, хяналт, үнэлгээ хийх зардал;

27.1.10.хууль тогтоомжид заасан бусад зардал.

27.2.Энэ зүйлийн 27.1.3-т заасан нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ нь халамжийн сангийн нийт хөрөнгөний 10 хувиас багагүй байна.

27.3.Халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

28 дугаар зүйл.Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгө

28.1.Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын санал болгосноор Улсын Их Хурал жил бүрийн Төсвийн тухай хуулиар тогтооно.

29 дүгээр зүйл.Халамжийн сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах

29.1.Халамжийн сангийн орлого, зарлагын тайланг доор дурдсан хугацаанд гаргаж тайлагнана:

29.1.1.аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тухайн сарын мэдээг дараа сарын 2-ны, тухайн жилийн эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 15-ны, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус тус гаргаж нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

29.1.2.нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн сарын мэдээг дараа сарын 4-ний, тухайн жилийн эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны, жилийн эцсийн тайланг дараа оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор гаргаж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлэх.

29.2.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага халамжийн сангийн жилийн эцсийн нэгдсэн тайлан, тэнцлийг хянан хэлэлцэж, дүгнэлт гаргана.

30 дугаар зүйл.Халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтын загвар батлах

30.1.Халамжийн сангийн мэдээ, тайлангийн маягтын загварыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

31 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн үйл ажиллагааны удирдлага

31.1.Нийгмийн халамжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутагт тухайн шатны Засаг дарга эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.

32 дугаар зүйл.Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо

32.1.Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн улсын ерөнхий байцаагч, улсын байцаагч, сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн /цаашид “нийгмийн ажилтан” гэх/-ээс бүрдэнэ.

32.2.Сум, хороонд ажиллах нийгмийн ажилтны жишиг нормативыг тухайн засаг захиргааны нэгжийн нийт хүн ам болон зорилтот өрх, иргэний тоо, ядуурлын түвшин, орон нутгийн онцлогыг харгалзан Засгийн газар тогтооно.

33 дугаар зүйл.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

33.1.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан яамны нийтлэг эрхлэх асуудлаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

33.1.1.улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийтлэг зорилтыг тодорхойлоход нийгмийн халамжийн үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаатай уялдуулан иргэдийн амьжиргааг дээшлүүлэх асуудлыг тусгах, салбар хоорондын харилцан хамаарлыг зохицуулах;

33.1.2.нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын нийгмийн халамжийн чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааг салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах;

33.1.3.гадаад улстай нийгмийн халамжийн асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, гэрээ конвенцэд нэгдэх асуудлыг судлах, шийдвэрлүүлэх.

34 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

34.1.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан агентлагийн нийтлэг эрхлэх асуудлаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1.нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

34.1.2.аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага, сум хорооны нийгмийн ажилтныг тасралтгүй сургах, мэргэшүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

34.1.3.энэ хуулийн 43.1, 43.4-т заасан гэрээний хэрэгжилтийг хангахад бүх шатны Засаг дарга нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, гэрээний хэрэгжилтийг тооцох чиг үүрэг бүхий нэгж ажиллуулах;

34.1.4.зорилтот өрх, иргэний хөгжлийг дэмжих үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үр дүнг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

34.1.5.нийгмийн халамжийн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, аюулгүй байдлыг хангах, технологийн дэвшлийг үйлчилгээнд нэвтрүүлэх, тооцоо, судалгаа боловсруулахад шаардлагатай тоон мэдээллээр төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай хангах.

34.2.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын чиг үүргийг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

34.3.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн нийгмийн халамжийн байгууллагад гурваас доошгүй жил ажилласан төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшүүлж нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тус тус томилж, чөлөөлнө.

35 дугаар зүйл.Нийгмийн халамжийн хяналт

35.1.Нийгмийн халамжийн байгууллага нь нийгмийн халамжийн арга хэмжээ болон үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий нийгмийн халамжийн улсын ерөнхий байцаагч болон нийгмийн халамжийн улсын байцаагчтай (цаашид нийгмийн халамжийн улсын байцаагч гэх) байна.

35.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь нийгмийн халамжийн улсын ерөнхий байцаагч байна. Улсын ерөнхий байцаагчийн эрхийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

35.3.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь хоёр хүртэлх тооны улсын байцаагчтай байна.

35.4.Нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрхийг нийгмийн халамжийн улсын ерөнхий байцаагч олгоно.

35.5.Нийгмийн халамжийн улсын байцаагч нь нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, ёс зүйн зөрчил гаргаагүй, дээд боловсролтой, мэргэшсэн, авлигад үл автах, нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн зэрэг шалгуурыг хангасан байна.

35.6.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.8-д заасны дагуу Засгийн газраас загварыг нь баталсан, уг улсын байцаагчийг томилох эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

35.7.Нийгмийн халамжийн улсын байцаагчийн хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

36 дугаар зүйл.Нийгмийн халамжийн улсын байцаагчийн бүрэн эрх

36.1.Нийгмийн халамжийн улсын байцаагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1.нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн халамжийн арга хэмжээний чанар, үр дүнд хяналт, үнэлгээ хийх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр нийгмийн халамжийн байгууллага, ажилтанд мэргэжлийн зөвлөгөө өгөх;

36.1.2.халамжийн сангийн орлого, зарлага, тайлан тэнцэл, санхүүгийн үйл ажиллагаанд цахим хэлбэрээр болон холбогдох баримт бичигт үндэслэн хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах;

36.1.3.тэтгэвэр, тэтгэмж тогтоох, дэмжлэг, үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийн магадлагаа хийхтэй холбогдсон санхүүгийн бусад баримтад хяналт шалгалт хийх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас тайлбар, лавлагааг үнэ төлбөргүй гаргуулан авах;

36.1.4.амьжиргааг дэмжих зөвлөл, нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах зорилтот өрх иргэнийг тодорхойлж байгаа орон тооны болон орон тооны бус комисс нийгмийн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа иргэн, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, баримт бичигт хяналт шалгалт хийх;

36.1.5.нийгмийн халамжийн улсын байцаагчийн акт, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр тогтоосон торгууль, алданги, хүүг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үл маргах журмаар гаргуулж, нийгмийн халамжийн санд төлүүлэх;

36.1.6.өөрийн хамаарал бүхий төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шалгалт хийхээр томилогдсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэж, уг шалгалтыг хийхээс татгалзах;

36.1.7.нийгмийн халамжийн хууль тогтоомж, стандарт, гэрээг зөрчих, хууль бус төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэрэг зөрчил гаргаж иргэн болон халамжийн санд хохирол учруулсан байгууллага, албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

36.1.8.нийгмийн халамжийн улсын байцаагчийн акт, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр тогтоосон торгууль, алданги, хүүг хугацаанд нь нийгмийн халамжийн санд төлүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

36.1.9.нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, дэмжлэгийн олголтод баримтын шалгалт хийх, илүү олгосон бол буцаан төлүүлэх, дутуу тооцож олгосон тохиолдолд нөхөн олгохоор акт тогтоох, актаар тогтоосон төлбөрийг барагдуулах;

36.1.10.албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн байгууллагын болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх, түүнийг хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, хяналт шалгалтын дүн, албан ёсны шийдвэр гараагүй байхад аливаа асуудлын талаар байр сууриа илэрхийлэхгүй байх, мэдээ, мэдээлэл тараахгүй байх;

36.1.11.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

37 дугаар зүйл.Нийгмийн халамжийн улсын байцаагчид хориглох зүйл

37.1.Нийгмийн халамжийн улсын байцаагч, нийгмийн ажилтны үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

37.1.1.удирдамж, томилолтгүйгээр хяналт шалгалт хийх;

37.1.2.нийгмийн халамжийн улсын байцаагчийн акт, албан шаардлага болон бусад баримт бичгийн хэвлэмэл хуудас, маягтыг үрэгдүүлэх, хууль бусаар хэвлэн ашиглах, хүчингүй буюу хуурамч хуудас хэрэглэх;

37.1.3.нийгмийн халамжийн улсын байцаагчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажуулах акт, бусад баримт бичгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан танилцуулах, зөвшөөрүүлэхээр албадах;

37.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон нийгмийн халамжийн улсын байцаагчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан акт, бусад баримт бичгийг засварлах, өөрчлөх;

37.1.5. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хууль бус зөвлөгөө өгөх, хууль тогтоомж зөрчихийг зөвлөх, ятгах, тулгах, шаардах;

37.1.6. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бичгээр гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн бүртгэлд бүртгэхгүй байх, уг бүртгэлд бүртгэгдээгүй өргөдөл, гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх;

37.1.7.нийгмийн халамжийн цахим мэдээллийн сангийн мэдээллийг хууль бусаар өөрчлөх, засварлах, устгах, сэргээх, хуурамч мэдээлэл оруулах, лавлагааг хуурамчаар гаргах, энэ талаар бусдад боломж олгох, улсын байцаагчийн тэмдэг, дардсыг хууль бусаар ашиглах, бусдад хэрэглүүлэх;

37.1.8.албан үүргээ гүйцэтгэх явцад байгууллагын болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулах, түүнийг хувийн ашиг сонирхлын төлөө ашиглах, хяналт шалгалтын дүн, албан ёсны шийдвэр гараагүй байхад аливаа асуудлын талаар байр сууриа илэрхийлэх, мэдээ, мэдээллийг задруулах;

37.1.9.хууль тогтоомжид заасан бусад хориглох зүйл.

38 дугаар зүйл.Нийгмийн ажилтан

38.1.Нийгмийн ажлын мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш түвшний боловсрол эзэмшсэн иргэнийг сум, хорооны нийгмийн ажилтнаар ажиллуулна. Сум, хорооны нийгмийн ажилтан нь төрийн захиргааны албан хаагч байна.

38.2.Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байна. Нийгмийн ажилтанд тавигдах шаардлага, ёс зүйн дүрмийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

38.3.Сумын нийгмийн ажилтныг сумын Засаг даргатай зөвшилцөн аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга, хорооны нийгмийн ажилтныг дүүргийн Засаг даргатай зөвшилцөн дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын дарга Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу томилж, чөлөөлнө.

38.4.Нийгмийн ажилтан дараах бүрэн эрхийн хэрэгжүүлнэ:

38.4.1.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах өрх, иргэний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэх;

38.4.2.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдсан зорилтот өрх, иргэнийг бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэх;

38.4.3.өрх, иргэнийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болоход нь туслах чиглэлээр зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийгмийн бусад үйлчилгээнд холбон зуучлах;

38.4.4.зорилтот өрх, иргэний амьжиргааг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээнд хамруулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

38.4.5.нийгмийн халамж шаардлагатай боловч хамрагдахгүй байгаа зорилтот өрх, иргэнийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх,;

38.4.6.Амьжиргааг дэмжих зөвлөлтэй хамтран нийгмийн халамжид хамрагдаж байгаа зорилтот, өрх иргэний амьдралтай газар дээр нь танилцах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон гэрээт байгууллагаас үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа эсэхэд хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаарх санал, тайлбарыг дээд байгууллагад хүргүүлэх;

38.4.7.иргэнд нийгмийн халамжийн арга хэмжээний зорилт, нөхцөл, болзол болон нийгмийн халамжийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын талаар мэдээлэл өгөх;

38.4.8.гэрээгээр нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай мэдээ, судалгаа, санхүүгийн тайлан түүнтэй холбоотой баримт, тайлбар, лавлагааг гаргуулан авах;

38.4.9.нийгмийн халамжийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэх, шаардлагатай бол дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

38.4.10.нийгмийн ажилтанд хандсан хувь хүний нууцыг хадгалах;

38.4.11.хууль тогтоомж болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

38.5.Нийгмийн ажилтан нь Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

38.5.1.сум, хороонд нийгмийн ажилтнаар ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн урамшуулал олгох;

38.5.2.ажлын үр дүнгээс хамаарч сар бүр үндсэн цалингийн 10-20 хувийн нэмэгдэл урамшуулал олгох;

38.5.3.энэ зүйлийн 38.4.6-д заасан болон бусад үйл ажиллагааны онцлогийг харгалзан үйл ажиллагааны зардлын дэмжлэг үзүүлэх.

39 дүгээр зүйл.Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл

39.1.Зорилтот өрх, иргэнийг энэ хуулийн 8.1, 13.1, 17.1-д заасан нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулах эсэх талаар дүгнэлт гаргах, нийгмийн ажилтантай хамтран халамж шаардлагатай өрх, иргэнийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх чиг үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ сум, хороонд ажиллана.

39.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргатай зөвшилцөн аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын дарга батална.

39.3.Зөвлөл нь 7 хүний гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл тус бүр 2 хүн, нийгмийн ажилтан багтана.

39.4.Зөвлөлийн гишүүнд сум, хороо, багийн Засаг дарга, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон тэргүүлэгч, иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгч нэрээ дэвшүүлэхийг хориглоно.

39.5.Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний төлөөллийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

39.6.2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно.

39.7.Зөвлөлийн гишүүдэд оролцоо, ажлын үр дүнг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгоно.

39.8.Зөвлөлийн ажиллах дүрэм болон гишүүдэд олгох урамшуулал, үйл ажиллагааны зардлын хэмжээг Засгийн газар батална.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

40 дүгээр зүйл.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

40.1.Нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдаж байгаа өрх, иргэн дараах үүргийг хүлээнэ:

40.1.1.өрхөд шинээр хүүхэд төрсөн, үрчлэн авсан, өрхийн гишүүн нас барсан эсхүл шилжиж ам бүлийн тоонд өөрчлөлт орсон бол сум, хорооны нийгмийн ажилтанд 14 хоногийн дотор мэдэгдэх;

40.1.2.нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдахдаа нийгмийн халамжийн хууль тогтоомжид заасан нөхцөл, шалгуурыг хангаж байгаа эсэхээ үнэн зөв мэдээлэх;

40.1.3.орон нутгаас зохион байгуулах хөдөлмөр эрхлүүлэх болон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцох.

40.2.Иргэн нь нийгмийн халамжийн арга хэмжээнд хамрагдах шаардлагатай зорилтот өрх, иргэний талаар тухайн орон нутгийн нийгмийн халамжийн байгууллага, нийгмийн ажилтан, нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

40.3.Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот өрх, иргэнд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулж дэмжлэг үзүүлж болно.

41 дүгээр зүйл.Бүх шатны Засаг даргын хүлээх үүрэг

41.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан нутаг дэвсгэрийн хүн амын ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

41.2.Энэ зүйлийн 41.1-д заасан зорилтыг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагыг татан оролцуулах, санал санаачилгыг дэмжиж, хамтран ажиллана.

41.3.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь энэ хуулийн 41.1-т заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр нийгмийн бусад үйлчилгээнд зорилтот өрх, иргэнийг тэргүүн ээлжид хамруулна.

41.4.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь тухайн орон нутгийн зорилтот өрх иргэнд энэ хуулийн 17.1-д заасан нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн халамжийн байгууллага, ажилтанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

41.5. Сум, дүүрэг, баг хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэртээ Орон нутгийн хөгжлийн төв, соёлын байгууллагаар дамжуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөгжлийн үйлчилгээг үзүүлэхэд иргэн, төрийн бус байгууллагад хууль тогтоомжид заасны дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

41.6.Баг, хорооны Засаг дарга нь зорилтот өрх, иргэнийг үнэн зөв тодорхойлж нийгмийн халамжийн болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

42 дугаар зүйл.Мэдээллийн нэгдсэн сан

42.1.Нийгмийн халамжийн байгууллага нь зорилтот, өрх иргэнийг тодорхойлох, нийгмийн халамжийн арга хэмжээг хүргэх, хүн амын өсөлтийг дэмжих тэтгэмж, хөнгөлөлт, урамшуулал олгох зорилгоор ашиглагдаж байгаа салбар дундын мэдээллийг багтаасан мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх)-тай байна.

42.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эзэмших, нууцлалыг хадгалах, шинэчлэх, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг хүлээнэ.

42.3.Мэдээллийн нэгдсэн сан нь нийгмийн халамжийн сан болон улсын төсвөөс олгосон санхүүжүүлэлтийн мэдээ, тайлан гаргах, тооцоо, судалгаа хийх, нэг өрхөд үзүүлж байгаа мөнгөн дэмжлэгийн хэмжээг тооцох, хяналт тавих, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

42.4.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг бүрдүүлэхдээ улсын бүртгэл, статистик, гааль, татвар, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, хүнс хөдөө аж ахуй, эрчим хүч зэрэг төрийн бусад байгууллагатай мэдээлэл солилцоно. Энэ үйл ажиллагаанд бүх шатны төрийн байгууллага үнэ төлбөргүй мэдээллээр ханган дэмжлэг үзүүлж ажиллана.

42.5.Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь мэдээллийн санд мэдээлэл оруулах, шинэчлэх, ашиглах, хадгалах ажлыг гүйцэтгэж мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

42.6.Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг устгах, хуульд өөрөөр заагаагүй бол өөрчлөх, дамжуулах, зориулалтын бусаар ашиглах, хуулбарлахыг хориглоно.

42.7.Мэдээллийн нэгдсэн сан дахь хуулиар хориглосноос бусад мэдээлэл нийтэд ил тод, нээлттэй байна.

42.8.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл солилцох, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

43 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийх

43.1. Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч баримт бичиг бүрдүүлсний улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийнэ.

43.2. Суутгалын хэмжээ нь тухайн иргэний сарын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээний 50 хувиас хэтэрч болохгүй.

43.3. Энэ хуулийн 43.1-т зааснаас бусад тохиолдолд иргэний тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно.

44 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

44.1. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.2. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

45.1. Энэ хуулийг 20.....оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ